



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар A/103

Батноров сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан (Байгал орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулагдах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам)-ын 3.5.5 дахь заалт, аймгийн Иргэдий Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 24 ний өдрийн 21 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн Захирамжлах нь:


1.Цагаан зээр хамгаалах өдрийг сурталчлан таниулах өдөрлөгийг 2025 оны 5 дугаар сарын 26 ны өдөр зохион байгуулсугай.

2. Арга хэмжээнд зарцуулах 2000000 (Хоёр сая) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү албаны нягтлан бодогч (Б.Энхжаргалд) зөвшөөрсүгэй.

3.Өдөрлөгийн үйл ажиллагааг батлагдсан төлөвлөгөөний дагуу чанартай зохион байгуулж холбогдох газруудад тайлагнаж ажиллахыг Соёлын төвийн захирал(П.Саранзаяа), Байгаль хамгаалагч(М.Ган-Эрдэнэ) нарт даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (А.Борчулуун)-нд үүрэг болгосугай.

ДАРГА



ОТГОНБАЯР